

Олборлох салбарын авлигын эрсдэлийг тодорхойлох төслийн дэд ажлын хэсгийн уулзалтын тэмдэглэл

2021 оны 9 сарын 8, Лхагва гараг, 10:00-12:30 цаг

Оролцогчид:

1. Ш.Цолмон, ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч
2. Б.Ганхуяг, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар
3. А.Пүрэв, Уул уурхай, үйлдвэрийн яам,
4. Б.Эрдэнэцэцэг, Нүүрс ассоциацийн
5. Д.Энхболд, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал
6. Д.Цэрэнжав, Ил тод байдал сан ТББ-ын тэргүүн,
7. Д.Сүхбаатар, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын удирдах зөвлөлийн
8. Л.Төр-Од, Транспаренси Интернэйшнл Монгол ТББ-ын тэргүүн
9. Н.Дорждарь, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (ББЗХ)-гийн Монгол дахь менежер
10. С.Боргил, Судлаач
11. Э.Мөнхжаргал, Судлаач
12. Б.Мөнхтогтох, Судлаач
13. Н.Золжаргал, ББЗХ

Хураангуй

Ш.Цолмон уулзалтыг нээж, хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Судлаач С.Боргил “Олборлох салбарын авлигын эрсдэлийг тодорхойлох” судалгааны үр дүнг танилцуулав. Дараах чиглүүлэх 3 асуулт бүхий асуумжийг Авлигатай тэмцэх газар (АТГ)-ын ажилтнууд, салбарын мэргэжилтнүүд, хуульчид, судлаачид, ТББ-ын төлөөлөл, төрийн өмчит компани болон хувийн хэвшлийн төлөөлөөс асууж, ярилцлага хийв.

1. Ямар учраас энэ төрлийн авлига маш ноцтой (хор хөнөөлтэй) вэ ?
2. Авлига гарах шалтгаан, эрсдэлт хүчин зүйлүүд юу вэ?
3. Авлигаас сэргийлэх болон эрсдэлт хүчин зүйлүүдийг бууруулах ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ?

Мөн албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл, бодит жишээ, тохиолдлууд болон бусад холбогдох материалыг судалсан. Судалгааны үр дүнд Олборлох салбарт ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийн “үйл ажиллагааны хүрээ”-д хамаарах дараах 7 төрлийн авлига байгааг тодорхойлсон. Үүнд:

1. Үйл ажиллагаа явуулахад түсгай зөвшөөрөл олгох, үнэлгээ, тайлан, төлөвлөгөө хүлээн авах болон дүгнэлт гаргахтай холбоотой авлига
2. Төрийн өмчит компани (ТӨК)-ийн худалдан авалт, туслан гүйцэтгэлтэй холбоотой авлига
3. Төрийн албан хаагчтай холбоотой үүсэх авлига
4. Татвар төлбөрөөс зугтах, үүргээ биелүүлэхээс зайлсхийхтэй холбоотой авлига
5. Компаниуд өөрсдийн зах зээлээ хадгалах, бизнесээ хамгаалахтай холбоотой авлига
6. Орон нутгийн удирдлага, эрх хэмжээнээс шалтгаалах авлига

7. Процесс хурдавчлахтай холбоотой авлига

Танилцуулгын дараа дэд ажлын хэсгийн гишүүд судалгааны талаар асуулт асуув.

- **Ш.Цолмон:** Mongolian IRS (internal revenue service) гэж дурдсан. Тэр талаар тодруулаач.
- **С.Боргил:** Энэ нь АНУд байдаг тогтолцоо. Миний санаа бол Монголын татварын байцаагч нарыг АТГ-ын нэг хэлтэс болгох. Орлогоо хуулийн дагуу мэдүүлж байгаа ч олсон орлогоосоо татвараа төлсөн үү гэдэг асуудал гарч ирнэ. Үүнийг шийдэхийн тулд хувь хүн болгон татвар төлсөн байх хэрэгтэй. Үүний хэрэгжилт дээр хяналт тавихыг АТГд харьцуулбал гэж зүгээр юм уу гэсэн саналаар оруулсан.

- **Д.Сүхбаатар:** 1. 12 төрлийн авлигыг товчилж 7 төрлийн авлига болголоо гэж байна. Үүнийг ямар шалгуураар ангилсан зэрэг дээр тайлбар өгөөч. 2. Дэлгэрэнгүй тайланг бас илгээж болох уу. 3. Offshore-т байгаа кейсүүдийг судалж үзсэн үү.

- **С.Боргил:** 12-оос ч илүү авлигын төрөл байна гэж үзсэн ч адил төстэй зүйл, давхардсан байгаа учраас ангилсан. Дэлгэрэнгүй тайланг имэйлээр явуулсан байгаа. Цаг хугацааны хувьд давчуу байсан учраас offshore-ын талаар судалгаа хийж амжсангүй ээ.

- **Л.Төр-Од:** Судалгааны үр дүнтэй санал нийлж байна. Дагнасан шүүх байгуулах талаар нэлээд ярьж байгаа ч яг одоо хэрэгжүүлж болохоор ажлууд юу байгаа вэ?

- **С.Боргил:** Дагнасан шүүх байгуулахыг хүлээхгүйгээр Авлигын хэргээр дагнасан шүүгчдийг бэлтгэж эхлэх нь зүгээр болов уу гэж харсан.

- **Н.Дорждарь:** Судалгааны явцад том жижиг компаниуд дээр ялгаатай байдал ажиглагдаж байсан уу? Байгаль орчны байдал дээр уул уурхайн яам болон байгаль орчны яам нэг чигт байгаа юу?

Тайлангаа сайжруулахдаа илүү зохимжтой ангилах хэрэгтэй юм уу гэсэн санал байна.

- **С.Боргил:** Том жижиг компани дээр ялгаа их байгаа. Том компаниуд илүү их авлигад өртсөн байгааг бодит жишээгээр нотолж байгаа. Байгаль орчны доройтол дээр салбарын яам хооронд ойлголтын зөрүү их байна гэж харж байгаа. Тайлан дээр таны хэлсэн саналыг хүлээж авч байна, илүү сайжруулна гэж бодож байгаа.

- **С.Цэрэнжав:** Уул уурхайн салбарт grand авлига ажиглагдаж байна уу?

- **С.Боргил:** Grand авлига байна гэж үзэж байгаа. Жишээ нь ашигт малтмалын тухай хууль батлагдахгүй хэд хэдэн УИХ дамнаж байна. Тендер зарлахдаа хүртэл тухайн компанид тааруулж тендерийн нөхцөлийг өөрчилж байгаа асуудал байгаа.

Дэд ажлын хэсгийн гишүүд эдгээр авлигын эрсдэлийг “Магадлал”, “Нөлөөлөл”, “Эерэг өөрчлөлт хийх боломж” гэсэн шалгуурыг хангаж байгаа эсэхийг үнэлж, тоогоор илэрхийлсэн оноо (1 = бага, 5 = их) өгч эрэмбэлж, дараах авлигын төрлүүдийг сонгов.

1. Төрийн албан хаагчтай холбоотой үүсэх авлига
2. Компаниуд өөрсдийн зах зээлээ хадгалах, бизнесээ хамгаалахтай холбоотой авлига
3. Орон нутгийн удирдлага, эрх хэмжээнээс шалтгаалах авлига

Эдгээр сонгогдсон авлигын төрлүүд дээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад гишүүд санал хэлэв.

Н.Дорждарь: Төрийн үйлчилгээг цахимжуулах гэдэг нь хэт ерөнхий байна. Яг юуг цахимжуулахыг тодорхой болговол зүгээр байна. Жишээ нь тусгай зөвшөөрөл олгох явцад орон нутгийн шийдвэр гаргалтыг цахим болгох, гаргасан шийдвэрийг ил тод болгох мөн холбогдох

газруудад цахимаар илгээх гэх зэргээр илүү нарийвчилж, ОУИТБС-ын хүрээнд хийж болох ажлыг тусгайлан судалж тусгах саналтай байна.

Д.Сүхбаатар: Төрийн албан хаагчид offshore-т байгаа хөрөнгөө мэдүүлж байх шаардлагатай гэж үзэж байна. Энэ талаар бид юу хийж болох вэ.

Б.Ганхуяг: Д.Сүхбаатарын саналтай холбоотойгоор тайлбар хэлье. Гадаадад байгаа хөрөнгийг ил болгохын тулд заавал тухай гадаад оронтой эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээтэй байх хэрэгтэй байдаг.

А.Пүрэв: Авлигатай холбоотой соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааг АТГ-тай хамтарч хийх нь зөв байх.

Ш.Цолмон: Орон нутгийн хандивын асуудлыг нэмж тусгах хэрэгтэй байх. ОУИТБС хандивын зарцуулалтыг шинээр маягтаар оруулж ирж байгаа. Үүнтэй холбоотойгоор хандив тусламжийн асуудлыг ил болгох гэж талаар үйл ажиллагааг оруулж болох уу.

А.Пүрэв: Орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулах хуулиар зохицуулсан байдаг. Гэтэл сумын гэрээг аймагтай байгуулах тохиолдол байдаг. Төслийн хэмжээгээр аймгийн засаг дарга байгуулна гэдэг заалт оруулж тодорхой болгох хэрэгтэй гэж бодож байгаа. Үүнийг одоо хэлэлцэж байгаа ил тодын хуульд оруулах шаардлагатай байх. Мөн хуулийг сурталчлах, өргөн таниулах арга хэмжээг тогтмол хийх гэсэн саналтай байна.

Н.Дорждарь: ОУИТБС-тай холбоотой ТББ болон хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллах, эрэн сурвалжлах сэтгүүлчтэй мэдээлэл солилцох, чадавхи бэхжүүлэх зэрэг ажлыг нэмж оруулах саналтай байна. Мөн энэ хурлаас гарсан саналуудыг дахин томъёолж засаад ОУИТБС-ын ажлын хэсэгт танилцуулах нь зүйтэй байх

Л.Төр-Од: 2022 оны 1 дүгээр сарын 1ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэх Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын холбогдох зүйл заалтуудыг авилгийн эрсдэл талаас нь нэг нягталж үзвэл зүйтэй болов уу...:: www.Legalinfo.mn - Хуулийн нэгдсэн портал сайт ::.. Мөн соён гэгээрүүлэх тал дээр Худалдаа аж үйлдвэрийн танхим дээр хамтран ажиллах боломжтой байгаа.

Ш.Цолмон хурлыг хааж үг хэлж, судалгааны үр дүн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг ОУИТБС-ын олон талт ажлын хэсэгт танилцуулахыг санал болгов.